Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

# ТОГТООЛ

1963 оны 10 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 471 | Улаанбаатар хот

Засварын анги байгуулах тухай.

БНМА Улсын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Хотын орон сууцны захиргаанд орон сууцны засварын анги, мөн хотын засварын контор сантехникийн засварын ангийг 1964 оноос эхлэн, аж ахуйн тооцооны үндсэн дээр байгуулан ажиллуулахыг зөвшөөрч, эдгээр хоёр ангид шаардагдах ажилчдыг түр курсээр бэлтгэх арга хэмжээ авахыг Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н.ЛУВСАНЧОЙМБОЛ/-д даалгасугай.

2.Орон сууцны засварын анги, сантехникийн засварын ангийн хэрэгцээнд шаардагдах барилгын гадаад, дотоод материалыг тусгайд нь хуваарилан олгож байхыг Улсын Төлөвлөгөөний Комисс /н.РЭНЦЭНПЭЛЖЭЭ/-д даалгасугай.

3.1964 оноос эхлэн, барилгын техникум төгсөн гарч байгаа барилга, сантехникийн мастер,техникч зэрэг мэргэжлийн хүмүүсээс хотын гүйцэтгэх захиргаанд хуваарилан өгч байхыг Барилга ба Барилгын Материалын Үйлдвэрийн Яам /н.ТЛЕЙХАН/-д даалгасугай.

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн орлогч дарга — ДУГЭРСҮРЭН

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг эрхлэх
газрын дарга — БАДАРЧ

Хуулбар үнэн:Тогтоол ангийн
эрхлэгчийг — /ДАВААЖАВ/